### 10.1 Чанарын үнэлгээ бүртгэх удирдамж

### 2 дугаар ангийн сурагчдаас авах монгол хэл, математикийн даалгаврын удирдамж

Чанарын үнэлгээний бүртгэл хийх гарын авлага

**Зорилго:** 2 дугаар ангийн сурагчдаас хичээлийн жил бүрийн эцэст монгол хэл, математикийн хичээлээр даалгавар авч, гүйцэтгэлийг Боловсролын салбарын мэдээллийн системээр дамжуулан БСШУСЯ-нд ирүүлнэ.

Энэ нь тухайн сургууль, багшийг үнэлэх, харьцуулах зорилготой бус, харин улсын хэмжээнд нэгтгэсэн нэг дүн гаргах бөгөөд цаашид төслийн үйл ажиллагааг төлөвлөхөд ашиглах зорилготой юм. Иймээс багш нараас даалгаврын дүнг үнэнч, шударгаар гаргаж өгөхийг хүсч байна.

**Хугацаа:** 5 дугаар сард багтаан сурагч бүрээс доорх даалгаврын гүйцэтгэлийг авч, 6 дугаар сарын 30-ны дотор Боловсролын салбарын мэдээллийн системд 2 дугаар ангийн багш нар өөрийн эрхээрээ шивж оруулна. БСУГ, хэлтсийн бага боловсрол хариуцсан мэргэжилтэн даалгаврын удирдамжийг 2 дугаар ангийн багш нарт хүргэнэ.

**БСМС дэх мэдээлэл:** Боловсролын салбарын мэдээллийн системд байрших дараах хүснэгтэд багш бүр өөрийн эрхээр нэвтэрч, сурагчдын гүйцэтгэлийг шивж илгээнэ.

*Хүснэгт 1. Даалгаврын гүйцэтгэлийн үнэлгээ*

| № | Анги | Сурагчийн нэр | Монгол хэл | Математик |
|---|---|---|---|---|